

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол шинжлэх ухааны сайд
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг

Агуулга

1.Төрийн аудитын САНАЛ, дүгнэлт.....	3
3.Аудитын тайлан	13
3.1. ЕРӨНХИЙ зүйл.....	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	13
3.3 Нягтлан БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ.....	14
3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ	14
3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	14
3.6. Төсвийн ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ	16
3.7. Шилэн ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ	18
3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ	18
3.9. Аудитын илрүүлэлт.....	18
Залруулсан алдаа.....	18
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	18
Аудитын зөвлөмж	19
3.10 Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	20
4. Менежментийн захидал.....	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	23



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БАГШИЙН МЭРГЭЖИЛ
ДЭЭШЛҮҮЛЭХ ИНСТИТУТИЙН
ЗАХИРАЛ Ж.БОЛОРМАА
ТАНАА

2021.02.25 № 07/584
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 1 хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний гүйцэтгэл 98.5 хувьтай байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар 43,462.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч тогтоосон материаллаг байдлын түвшингөөс 4,934.4 мянган төгрөгөөр давсан нь дангаараа болон эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	79,457,805.03	316,782,178.08
33	АВЛАГА	34,620,547.97	268,581,864.08
33300	Татаас, санхүүжилтийн авлага	34,615,864.08	268,581,864.08
335	Бусад авлага	4,683.89	00.00
3351	Байгууллагаас авах авлага	4,683.89	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	44,837,257.06	48,200,314.00
351	Түүхий эд материал	13,901,890.00	13,901,890.00
35110	Тусгай зориулалттай материал	13,901,890.00	13,901,890.00
354	Хангамжийн материал	30,935,367.06	34,298,424.00
35410	Бичиг хэргийн материал	4,380,000.00	603,430.00
35420	Аж ахуйн материал	24,925,367.06	32,264,994.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,430,000.00	1,430,000.00
35440	Түлш, шатах тослох материал	200,000.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,194,699,878.23	6,292,297,036.18
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,194,699,878.23	6,292,297,036.18
392	Биет хөрөнгө	6,194,699,878.23	6,289,554,536.18
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,195,347,418.00	6,195,347,418.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(95,313,037.20)	(190,626,074.40)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	173,811,653.00	109,101,653.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(173,811,653.00)	(44,391,653.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	421,396,092.36	183,652,237.55
39206	Хуримтлагдсан элэгдэл	(412,238,408.90)	(24,716,756.66)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	243,201,022.20	243,201,022.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	(157,820,198.23)	(182,140,300.51)
39217	Номын фонд	126,990.00	126,990.00
393	Биет бус хөрөнгө		2,742,500.00
39301	Програм хангамж	8,762,400.00	2,742,500.00
39302	Хасагдуулга	(8,762,400.00)	00.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,274,157,683.26	6,609,079,214.26
	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		8,840,000.00
	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		8,840,000.00
413	ӨГЛӨГ		8,840,000.00
4136	Байгууллагад төлөх өглөг		8,840,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,274,157,683.26	6,600,239,214.26
51	Засгийн газрын хувь оролцоо	6,274,157,683.26	6,600,239,214.26
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	6,615,693,446.20	6,615,693,446.20
51101	Өмч: - төрийн	6,615,693,446.20	6,615,693,446.20
512	Хуримтлагдсан үр дүн	(1,306,502,778.44)	(980,421,247.44)
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,306,502,778.44)	(1,306,502,778.44)
51220	Тайлант үеийн үр дүн		326,081,531.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	964,967,015.50	964,967,015.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,274,157,683.26	6,609,079,214.26

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,530,079,809.40	2,252,498,024.55
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	19,876,200.00	229,756,037.55
120	Нийтлэг татварын бус орлого	19,876,200.00	229,756,037.55
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	19,876,200.00	229,756,037.55
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,285,000.00	6,880,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,591,200.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		222,876,037.55
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,510,203,609.40	2,022,741,987.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,141,474,700.00	1,413,943,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,141,474,700.00	1,413,943,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,368,728,909.40	608,798,487.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	26,530,975.41	81,334,440.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	950,031,156.00	252,662,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,392,166,777.99	274,801,747.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	00.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,770,620,712.33	1,926,416,493.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,770,620,712.33	1,926,416,493.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,762,559,474.40	1,846,969,331.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,344,548,962.35	1,106,943,164.56
210101	Үндсэн цалин	1,210,370,446.35	844,058,311.56
210102	Нэмэгдэл	47,773,516.00	161,651,853.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	86,405,000.00	101,233,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	176,850,861.19	144,746,330.41
210201	Тэтгэврийн даатгал	145,347,918.19	107,684,930.41
210202	Тэтгэмжийн даатгал	7,947,037.75	9,265,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,326,911.40	7,412,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,566,271.35	1,853,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,662,722.50	18,530,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	161,012,600.40	147,716,157.93
210301	Гэрэл, цахилгаан	120,038,299.16	112,766,899.00
210302	Түлш, халаалт	31,723,701.24	27,827,028.93
210303	Цэвэр, бохир ус	9,250,600.00	7,122,230.00
2104	Хангамж, бараа материалын зардал	136,219,611.00	46,428,546.48
210401	Бичиг хэрэг	92,983,945.00	20,653,111.06
210402	Тээвэр, шатахуун	7,793,100.00	7,137,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,398,219.60	9,023,487.42
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,670,000.00	4,376,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,989,346.40	5,237,648.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	385,000.00	00.00
	Нормативт зардал		800,000.00
210501	Эм тариа, эмнэлэгийн хэрэгсэл		800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,631,800.00	5,027,700.00
210604	Урсгал засвар	29,631,800.00	5,027,700.00
2107	Томилолт, зочны зардал	4,198,620.00	00.00

210702	Дотоод албан томилолт	4,198,620.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	52,035,978.00	52,370,513.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	42,405,978.00	43,796,853.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,900,000.00	5,500,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,730,000.00	3,073,660.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,858,061,041.46	342,936,919.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,265,399.38	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,656,031,607.23	217,658,040.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	191,764,034.85	125,278,879.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,061,237.93	79,447,161.57
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,500,000.00	57,051,397.00
213207	Тэтгэвэрт гарахад олгодог нэг удаагийн мөнгөн тэтгэмж		52,378,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,500,000.00	4,673,097.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,561,237.93	22,395,764.57
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,198,966.53	22,375,846.54
213304	Хөрөнгийн		
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	362,271.40	19,918.03
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-240,540,902.93	326,081,531.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-240,540,902.93	326,081,531.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,516,488,609.40	2,064,237,851.08
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,285,000.00	6,880,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,285,000.00	6,880,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,285,000.00	6,880,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,285,000.00	6,880,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,510,203,609.40	2,057,357,851.08
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,141,474,700.00	1,413,943,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,141,474,700.00	1,413,943,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,368,728,909.40	643,414,351.08
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	26,530,975.41	81,334,440.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	950,031,156.00	252,662,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,392,166,777.99	309,417,611.08
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,516,488,609.40	2,064,237,851.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,516,488,609.40	2,064,237,851.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,473,811,507.39	1,716,208,825.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,344,548,962.35	1,106,943,164.56
210101	Үндсэн цалин	1,210,370,446.35	844,058,311.56
210102	Нэмэгдэл	47,773,516.00	161,651,853.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	86,405,000.00	101,233,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	136,031,301.04	144,741,646.52
210201	Тэтгэврийн даатгал	105,579,820.47	107,680,246.52
210202	Тэтгэмжийн даатгал	7,032,902.40	9,265,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,443,858.89	7,412,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,265,075.48	1,853,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,709,643.80	18,530,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	160,802,400.40	147,716,157.93
210301	Гэрэл, цахилгаан	120,038,299.16	112,766,899.00
210302	Түлш, халаалт	31,571,201.24	27,827,028.93
210303	Цэвэр, бохир ус	9,192,900.00	7,122,230.00
2104	Хангамж, бараа материалын зардал	69,291,307.60	44,500,603.42
210401	Бичиг хэрэг	40,644,051.00	19,010,800.00
210402	Тээвэр, шатахуун	8,655,000.00	6,937,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,048,219.60	9,023,487.42
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,800,000.00	4,376,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,144,037.00	5,152,016.00
2105	Нормативт зардал		800,000.00
210501	Эм бэлдмэл эмнэлэгийн хэрэгсэл		800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,960,476.00	5,960,500.00
210604	Урсгал засвар	14,960,476.00	5,960,500.00
2107	Томилолт, зочны зардал	15,979,700.00	00.00
210702	Дотоод албан томилолт	15,979,700.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	63,184,200.00	44,159,513.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	52,377,200.00	34,956,853.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,900,000.00	5,500,000.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,907,000.00	3,702,660.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,669,013,160.00	221,387,240.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,669,013,160.00	221,387,240.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,677,102.01	348,029,025.65
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,500,000.00	57,051,397.00
213207	Тэтгэвэрт гарахад олгодог нэг удаагийн мөнгөн тэтгэмж		52,378,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,500,000.00	4,673,097.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	39,177,102.01	290,977,628.65
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,198,966.53	22,375,846.54
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	34,978,135.48	268,601,782.11
111	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
6	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
101	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,615,693,446.20	964,967,015.50	(1,065,961,875.51)	6,514,698,586.19
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,615,693,446.20	964,967,015.50	(1,065,961,875.51)	6,514,698,586.19
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	(240,540,902.93)	(240,540,902.93)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,615,693,446.20	964,967,015.50	(1,306,502,778.44)	6,274,157,683.26
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,615,693,446.20	964,967,015.50	(1,306,502,778.44)	6,274,157,683.26
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	326,081,531.00	326,081,531.00
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,615,693,446.20	964,967,015.50	(980,421,247.44)	6,600,239,214.26

2.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант 2020 оны 12 дугаар сарын
хугацаа: 31-ний өдрөөр дуусвар
болсон тайлан

/төгрөгөөр /

		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,420,183,500.00	1,398,447,653.46	21,735,846.54	98.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,420,183,500.00	1,398,447,653.46	21,735,846.54	98.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,363,122,800.00	1,341,396,256.46	21,726,543.54	98.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	985,533,900.00	983,757,462.06	1,776,437.94	99.8
210101	Үндсэн цалин	723,757,700.00	720,872,609.06	2,885,090.94	99.6
210102	Нэмэгдэл	160,976,200.00	161,651,853.00	-675,653.00	100.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	100,800,000.00	101,233,000.00	-433,000.00	100.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	129,785,000.00	127,730,720.05	2,054,279.95	98.4
210201	Тэтгэврийн даатгал	92,723,600.00	90,669,320.05	2,054,279.95	97.8
210202	Тэтгэмжийн даатгал	9,265,400.00	9,265,400.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,412,200.00	7,412,200.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,853,100.00	1,853,100.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	18,530,700.00	18,530,700.00	0.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	152,102,500.00	147,716,157.93	4,386,342.07	97.1
210301	Гэрэл, цахилгаан	113,838,300.00	112,766,899.00	1,071,401.00	99.1
210302	Түлш, халаалт	30,580,600.00	27,827,028.93	2,753,571.07	91.0
210303	Цэвэр, бохир ус	7,683,600.00	7,122,230.00	561,370.00	92.7
2104	Хангамж, бараа материалын зардал	36,037,800.00	31,271,903.42	4,765,896.58	86.8
210401	Бичиг хэрэг	6,782,100.00	5,782,100.00	1,000,000.00	85.3
210402	Тээвэр, шатахуун	6,942,700.00	6,937,800.00	4,900.00	99.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,208,400.00	9,023,487.42	184,912.58	98.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,376,500.00	4,376,500.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,728,100.00	5,152,016.00	3,576,084.00	59.0
2105	Нормативт зардал	800,000.00	800,000.00	0.00	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	800,000.00	800,000.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,684,600.00	5,960,500.00	8,724,100.00	40.6
210604	Урсгал засвар	14,684,600.00	5,960,500.00	8,724,100.00	40.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,179,000.00	44,159,513.00	19,487.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	34,968,400.00	34,956,853.00	11,547.00	100.0

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,500,000.00	5,500,000.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,710,600.00	3,702,660.00	7,940.00	99.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57060700.00	57051397.00	9,303.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	57,060,700.00	57,051,397.00	9,303.00	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	52,378,300.00	52,378,300.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,682,400.00	4,673,097.00	9,303.00	99.8
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,420,183,500.00	1,398,447,653.46	21,735,846.54	98.5
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,413,943,500.00	1,391,567,653.46	22,375,846.54	98.4
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,413,943,500.00	1,391,567,653.46	22,375,846.54	98.4
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих			0.00	
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	6,240,000.00	6,880,000.00	(640,000.00)	110.3
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,240,000.00	6,880,000.00	(640,000.00)	110.3
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	70.00	74.00	4.00	105.7
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	49.00	53.00	4.00	108.2
620003	Үйлчлэх ажилтан	20.00	20.00	0.00	100.0

2.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

		/ төгрөгөөр/
ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		643,414,351.08
УРСГАЛ ЗАРДАЛ		643,414,351.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		374,812,568.97
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		123,185,702.50
Үндсэн цалин		123,185,702.50
Нэмэгдэл		
Унаа хоолны хөнгөлөлт		
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		17,010,926.47
Тэтгэврийн даатгал		17,010,926.47
Хангамж, бараа материалын зардал		13,228,700.00
Бичиг хэрэг		13,228,700.00
Бараа үйлчилгээний буёад зардал		221,387,240.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		221,387,240.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		268,601,782.11
Олгосон санхүүжилт шилжүүлэг		268,601,782.11
Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		268,601,782.11
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		643,414,351.08
Нэмэлт санхүүжилтийн орлого		643,414,351.08
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж		81,334,440.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсвөөс доод шатны төсөвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		252,662,300.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		309,417,611.08

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг байгууллагын Ерөнхий менежер Ж.Болормаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хууль, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, анхан шатны баримтын бүрдлийг хангах, бараа материал эд хөрөнгийн тооллогыг үндэслэн тооцоог бодож бүртгэлд тусгах, автомашиныг зориулалтын дагуу ашиглах, төсвийн төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулах, өр төлбөр үүсгэхгүй ажиллах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 22-ноос 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд “Цэгцтөв богд аудит” ХХК-ийн захирал Н.Цэрэнханд, аудитор Г.Цэцэгмаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газар-т 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 1/13 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын эрхэм зорилго: Сургуулийн өмнөх боловсрол, бага дунд боловсролын сургалтын байгууллагын багш ажилтны мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих үйл ажиллагааг боловсролын хөгжлийн бодлого болон нийгмийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан орчин үеийн мэдээлэл харилцааны технологид суурилж олон улсын жишигт нийцүүлэн зохион байгуулж, хүний хөгжлийг дээдлэн, боловсон хүчний мэдлэг, чадварыг тасралтгүй дээшлүүлж, чадварлаг, ёс зүйтэй хамт олныг бүрдүүлэх салбарынхаа тэргүүлэгч байгууллага болно гэж тодорхойлжээ.

Үйл ажиллагааны чиг үүрэг: Үндэсний түвшинд Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын багш, удирдах болон бусад ажилтны мэргэжлийг боловсролын хөгжлийн бодлого, тэдний эрэлт хэрэгцээнд тулгуурлан үндсэн, төрөлжсөн, онлайн зайны хэлбэрээр байнга, тасралтгүй дээшлүүлэх чиг үүрэг бүхий сургалт, арга зүй, судалгааны байгууллага мөн.

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Байгууллагын удирдлага, дотоод үйл ажиллагааны зохион байгуулалт, харилцаа, хамтын ажиллагааны менежментийг сайжруулах
- Багш мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих үйл ажиллагааны чанар, хүртээмж, үр дүнг дээшлүүлэн зохион байгуулах
- Байгууллагын хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлэх
- Санхүү эдийн засгийн төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг чанаржуулах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх

- Байгууллагын материаллаг бааз, техник, тоног төхөөрөмж, технологийн орчныг бэхжүүлэх
- Байгууллагын хөгжлийн төлөвлөгөө, үйл ажиллагааны чиглэлтэй уялдуулан нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Бага дунд боловсролын тухай
- Багшийн хөгжлийг дэмжих тухай
- Дээд боловсролын тухай
- Мэргэжлийн боловсрол сургалтын тухай
- Сургуулийн өмнөх боловсролын тухай
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Багшийн мэргэжил дээшлүүлэх институт санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 893,550.9 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 17,871.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,926,416.5 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 38,528.3 мянган төгрөгөөр тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 334,921.5 мянган төгрөгөөр буюу 5.3

хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	34,620.5	268,581.8	233,961.3
Бараа материал	44,837.2	48,200.3	3,363.1
Үндсэн хөрөнгө	6,194,699.9	6,292,297.0	97,597.1
Нийт хөрөнгө	6,274,157.7	6,609,079.2	334,921.5
Өр төлбөр	-	8,840.0	8,840.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6,274,157.7	6,600,239.2	326,081.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,274,157.7	6,609,079.2	334,921.5

Авлага дансны үлдэгдэл 268,581.8 мянган төгрөг болж 233,961.3 мянган төгрөгөөр өссөн нь нэмэлт санхүүжилтийн төсвөөс санхүүжих боловсролын чанарын шинэчлэл төслийн 42,091.8 мянга, дээд боловсролын шинэчлэл төслийн 226,490.0 мянган төгрөгийн санхүүжилт оны эцэст татан төвлөрүүлж буцаан авахаар авлага үүсгэснээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 48,200.3 мянган төгрөг болж 3,363.1 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэргийн материал 3,776.6 мянган төгрөгөөр буурч аж ахуйн материал 7,339.7 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд он удаан жил болсон ашиглалтгүй бараа материал байхгүй.

Үндсэн хөрөнгийн биет хөрөнгө дансны үлдэгдэл 6,289,554.5 мянган төгрөг болж 94,854.6 мянган төгрөгөөр өссөн нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрээр элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн цаашид ашиглах боломжтой хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж үнийг шинэчлэн тогтоож нэмэгдүүлсэн, цаашид ашиглах боломжгүй болсон хөрөнгийг ашиглалтаас хассанаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн биет хөрөнгийн данс нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн “Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох, зөвшөөрөл олгох тухай” 502 дугаар тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хэдий ч цаашид ашиглах боломжтой авто тээврийн хэрэгслийг 64,710.0 мянга, 84 нэр төрлийн машин тоног төхөөрөмжийг 109,539.2 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоож ашиглалтын хугацааг сунгасан, үнэ төлбөргүй шилжиж ирсэн машин тоног төхөөрөмж 45,884.3 мянган төгрөг нийт 220,133.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ч цаашид ашиглах боломжтой гэж үнийг шинэчлэн тогтоосны хорогдол авто тээврийн хэрэгсэл 129,420.0 мянга, тоног төхөөрөмж 357,233.5 мянга, акталсан тоног төхөөрөмж 35,933.9 мянга, нийт 522,587.4 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгө элэгдлээрээ анхны өртөгөө бүрэн нөхөж үлдэх өртөггүй болсон.

Биет бус хөрөнгийн оны эцсийн үлдэгдэл 2,742.5 мянган төгрөг болж өссөн нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн “Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох, зөвшөөрөл олгох тухай” 502 дугаар тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хэдий ч цаашид ашиглах боломжтой 3 төрлийн программ хангамжийг 2,742.5 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоож ашиглалтын хугацааг сунгасан, программ хангамжийн үнийг шинэчлэн тогтоосны хорогдол 3,990.0 мянган төгрөг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 10 дугаар

сарын 08-ны өдрийн А-1/1749 тоот “Зөвшөөрөл олгох тухай” албан бичгийг үндэслэн элэгдлээрээ анхны өртөгөө нөхсөн цаашид ашиглах боломжгүй болсон 4,772.4 мянган төгрөгийн программ хангамжийг аклан данснаас хассанаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 8,840.0 мянган төгрөг болж 8,840.0 мянган төгрөгөөр өссөн нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг хассанаас Бумбат зүрх ХХК-д харуул хамгаалалтын хөлсийг төлөөгүйгээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 6,600,239.2 мянган төгрөг болж 326,081.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,277,581.8 мянган төгрөгөөр буюу 36.1 хувиар буурсан байна.

Энэ нь дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын хөл хорионы улмаас танхимын сургалтын ажлууд явагдаагүйтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 1,844,204.2 мянган төгрөгөөр буюу 48.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал 1,438,373.5 мянга, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 66,485.1 мянга, цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 237,605.8 мянган төгрөгөөр буурсан, тэтгэвэрт гарахад олгодог нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардал 52,378.3 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны 472 дугаар тогтоолоор төрийн албаны цалингийн сүлжээ нэмэгдсэн, 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын дагуу төрийн албаны нэмэгдэл олгосон, 2 ажилтан төрийн албанаас тэтгэвэр тогтоолгон чөлөөлөгдсөнтэй холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,931,336.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,931,336.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 569,687.8 мянган төгрөгөөр бууруулж 1,361,648.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн төсөл, өмнөх оны баталсан төсвөөс цалингийн нэмэгдэл, үр дүнгийн урамшуулал, гадаад албан томилолт, зочны зардлыг Ковид-19 цар тахалтай холбогдуулан онлайнаар ажиллаж байгаа нөхцөлд тэвчиж болох зардал гэж үзэж хассан, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас материаллаг хэмжээний буюу 52,070.0 мянган төгрөгийг хассан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид 58,534.7 мянган төгрөгийг хуваарилж 1,420,183.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,413,943.5 мянган төгрөгийг улсын төсвөөс 6,240.0 мянган төгрөгийг

үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр дээд шатны байгууллага баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,413,943.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 6,880.0 мянган төгрөг, нийт 1,420,823.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,398,447.7 мянган төгрөгийг зарцуулж 22,375.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,398,447.6 мянган төгрөг буюу 98.5 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 1,776.4 мянга, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 2,054.3 мянга, байр ашиглалттай холбоотой зардлыг 4,386.3 мянга, хангамж бараа материалын зардлыг 4,765.9 мянга, эд хогшил худалдан авах зардлыг 8,724.1 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 19.5 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 9.3 мянга нийт 21,735.8 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь Боловсролын бодлого удирдлага хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны зардал арга хэмжээ 21,726.5 мянган төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг арга хэмжээ 9.3 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71808	Боловсролын бодлого удирдлага	1,420,183.5	1,398,447.7	21,735.8	98.5%
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,363,122.7	1,341,396.2	21,726.5	98.4%
1.2	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	57,060.8	57,051.5	9.3	99.8%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 81,334.4 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 252,662.3 мянга, “Нээлттэй нийгэм форум” төрийн бус байгууллагаас санхүүжүүлж хамтран зохион байгуулсан “Тэгш хамруулан сургах боловсрол”-ын тэтгэлэгт үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 14,144.2 мянга, бусад төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан 295,273.4 мянга нийт 643,414.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 123,185.7 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 17,010.9 мянга, хангамж бараа материалын зардалд 13,228.7 мянга, хичээл үйлдвэрлэлийн зардалд 221,387.2 мянга нийт 374,812.5 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 268,601.8 мянган төгрөгөөс 268,581.9 мянган төгрөгийг авлагад тооцон буцаан авахаар Сангийн яамны төрийн сангийн газартай тооцоо нийлж баталгаажуулан 19.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд мэдээлбэл зохих 151 мэдээллээс хугацаандаа мэдээлсэн 62, хугацаа болоогүй 2, хугацаа хоцроосон 8, мэдээлээгүй 79 мэдээлэл байна.

Шилэн дансны тухай хуулийн 6.4.8-д заасан төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, холбогдох тушаал шийдвэрүүдийг байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 766.8 мянган төгрөгийн 4 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
					Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	4	766.8	4	766.8	4	100	100
Нийт дүн	4	766.8	4	766.8	4	100	100

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 220,454.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 176,991.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 25,045.9 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 18,416.8 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой 85 нэр төрлийн 174,249.2 мянган төгрөгийн биет хөрөнгө, 3 нэр төрлийн 2,742.5 мянган төгрөгийн биет бус хөрөнгийг ТӨБЗГ-аас ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгож санхүүгийн тайлангийн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансанд бүртгэснийг үнэ төлбөргүй хүлээн авсан орлогод бүртгүүлж санхүүгийн тайланд залрууллаа.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 43,462.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 25,045.9 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлээ Үүнд:

1. Ажилгүй байсан хугацааны цалингийн нөхөн олговор 10,045.9 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй цалингийн сангаас Ж.Болормаад олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д “13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”,

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

2. Ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагч, эцэг эхчүүдэд хандсан видео шторк бэлтгэх ажлын 15,000.0 мянган төгрөгийн үнийн дүн бүхий багц ажлыг 2 байгууллагатай шууд гэрээ байгуулан гүйцэтгэсэн нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

3. Тайлант хугацаанд мэдээлбэл зохих 151 мэдээллээс хугацаандаа мэдээлсэн 62, хугацаа болоогүй 2, хугацаа хоцроосон 8, мэдээлээгүй 79 мэдээлэл байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”; 6 дугаар зүйлийн 6.4.8-д “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 18,416.8 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын захирлын ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт цалингийн зардлаас 10,045.9 мянган төгрөгийг Төсвийн ерөнхийлөн захирагч нь ямар нэгэн тушаал шийдвэргүйгээр цалингийн төсвөөс олгох чиглэл өгсөний дагуу анхан шатны баримтгүй олгосныг анхаарч үзэх,

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаатай холбоотой аудит хийх цар хүрээ хязгаарлагдаж, байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн, анхан шатны баримт материалуудыг бүрэн хамруулж, хөрөнгийн биет тооллого хийх, төсвийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Ажил гүйлгээг бүртгэлд тусгахдаа дахин давтагдахгүй дугаар бүхий худалдан авалтын баримтгүй, зарлагын баримтын бүрдлийг хангаагүй, бараа материал, шатахууны 154.5 мянган төгрөгийн тооцоо бодоогүй, акт үйлдэж, үр дүнг тооцоогүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэлгээ, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийг буруу илэрхийлэх, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, тохиолдсон байх батламж мэдэгдэл хангагдахгүй байх

1.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.4, мөн хуулийн 20.2.6 дахь заалтыг хангаж ажиллах

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Балансын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Нэмэлт санхүүжилтээр гүйцэтгэсэн ажлын хөлсний төсөвт ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл төсөвлөгдөөгүй учраас ажил олгогчийн төлөх 9,422.3 мянган төгрөгийг даатгуулагчаас суутган нийгмийн даатгалд төлсөн нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.7-д "төсвийн шууд захирагч нь батлагдсан төсвийг энэ хуулийн 22.2.3, 22.2.6-д заасан ангиллаар бүртгэж, тайлагнах" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Эрсдэл:

Даатгуулагчид хохирол учруулах, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдэл хангагдахгүй байна.

2.3. Зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6. дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийг тусад нь төсөвлөж олгоно.

3. Балансын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Бумбат зүрх ХХК-д харуул хамгаалалтын гэрээний дагуу төлөх 8,840.0 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлын төсвийг хасаж баталсны

улмаас өглөг үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл. Төсвийн зарчмыг хэрэгжүүлэх 6.4.8. Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх. гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Эрсдэл:

Хөрөнгийн чадвар муудах, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдахгүй байх.

3.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Сангийн яам байгууллагуудын төсвийг хассаны улмаас өр үүссэн, Өглөгийг төсвийн гүйцэтгэлийн тайлан болон албан бичгээр харьяа байгууллагуудад мэдэгдэж, санхүүжилтийг хүссэн боловч шийдвэрлэгдээгүй. Бумбат зүрх ХХК-тай тооцоо нийлж өглөгийг баталгаажуулсан.

4. Дотоод хяналттай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт:

Суудлын автомашиныг албан тушаалын болон албан ажлын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалтын дагуу зориулалтаар нь хэрэглээгүй нь Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан " Албан тушаалын болон албан ажлын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаал"-д заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2. Эрсдэл:

Суудлын автомашин ашиглах журам зөрчигдөж, зардал нэмэгдэх, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдэл хангагдахгүй байх.

4.3 Өгсөн зөвлөмж:

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан " Албан тушаалын болон албан ажлын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаал"-ыг мөрдөж ажиллах.

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах болно.

5. Дотоод хяналттай холбоотой асуудал

5.1 Илрүүлэлт:

Төрийн албанд ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгон төрийн албанаас чөлөөлөгдсөн нэр бүхий иргэдийг дахин төрийн албанд үндсэн орон тоон дээр авч ажиллуулж Засгийн газрын тогтоолоор батлагдсан цалингийн сүлжээг баримтлан цалин олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3."хөдөлмөрийн гэрээ" гэж нэг талаас ажилтан нь ажил олгогчоос хуульд нийцүүлэн тогтоосон хөдөлмөрийн дотоод журмын дагуу тодорхой ажил гүйцэтгэх, нөгөө талаас ажил олгогч нь ажилтанд хөдөлмөрийн үр дүнд тохирсон цалин хөлс олгох, хууль тогтоомж болон хамтын гэрээ, хэлэлцээрт заасан хөдөлмөрийн нөхцөлөөр хангах тухай харилцан үүрэг хүлээсэн тохиролцоог; 21 дүгээр зүйлийн 21.1.3-т "үндсэн цалин буюу албан тушаалын цалингийн хэмжээ", 50 дугаар зүйлийн 50.3-т "Нэмэгдэл хөлсийг энэ хууль болон хамтын гэрээгээр тогтоосон хэмжээгээр ажил олгогч ажилтантай тохиролцон тогтооно", гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2. Эрсдэл:

Холбогдох хуулийн заалтууд зөрчигдөх, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдэл хангагдахгүй байх.

5.3 Өгсөн зөвлөмж:

Тэтгэвэр тогтоолгосон иргэнийг төрийн албанд дахин авч ажиллуулахдаа Хөдөлмөрийн тухай хуулийн 21.1.3, 50.3 заалтуудыг хангаж ажиллах.

5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хуулийн заалтыг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:

2021

Аудитын нэр:

Шалгагдсан байгууллагын нэр:

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Багшийн мэргэжил дээшлүүлэх институт

Аудитын код:

САГ-2020 /43/ СТА-ТШЗ

Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Ажил гүйлгээг бүртгэлд тусгахдаа дахин давтагдахгүй дугаар бүхий худалдан авалтын баримтгүй, зарлагын баримтын бүрдлийг хангаагүй, бараа материал, шатахууны 154.5 мянган төгрөгийн тооцоо бодоогүй, акт үйлдэж, үр дүнг тооцоогүй байна.	154.5	Зөвлөмж өгөх	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Ж.Болормаа С.Бадам
2	Нэмэлт санхүүжилтээр гүйцэтгэсэн ажлын хөлсний төсөвт ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг тусгагдаагүй ажлын хөлсийг олгоходоо даатгуулагчаас суутган нийгмийн даатгалд төлсөн.	9,422.3	Зөвлөмж өгөх	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Ж.Болормаа С.Бадам
3	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал хүрэлцээгүйн улмаас харуул хамгаалалтын байгууллагад өглөг үүсгэсэн	8,840.0	Зөвлөмж өгөх	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Ж.Болормаа С.Бадам
4	Суудлын авто машиныг албан тушаалын болон албан ажлын суудлын авто машин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалтын дагуу, зориулалтаар нь хэрэглээгүй байна.		Зөвлөмж өгөх	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Ж.Болормаа С.Бадам
5	Ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагч, эцэг эхчүүдэд хандсан видео шторк бэлтгэх ажлын үнийн дүнг хувааж хоёр байгууллагатай шууд гэрээ байгуулан ажлыг гүйцэтгэсэн.	15,000.0	Албан шаардлага өгөх	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Ж.Болормаа С.Бадам
6	Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн захирал нь эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр 10,045.9 мянган төгрөгийг цалингийн сангаас өөртөө олгосон байна.	10,045.9	Албан шаардлага өгөх	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Ж.Болормаа С.Бадам
7	Төрийн албан ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон иргэнийг дахин төрийн албанд ажиллуулахдаа төрийн албаны цалингийн сүлжээний шатлалаар цалинжуулсан		Зөвлөмж өгөх	Захирал	Ж.Болормаа
8	Байгууллагын шилэн дансны цахим сайтад байршуулах нийт 151 мэдээллээс хугацаа хоцроосон 8 мэдээлэл, мөн төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, тушаал шийдвэрийн 79 мэдээллийг цахим хуудсанд байршуулаагүй байна.		Албан шаардлага өгөх	Захирал	Н.Даваацэрэн
ДҮН		43,462.7			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 21/АО/60058
САГ-2021/43/СТА-ТМЗ
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын захирал нь эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр 10,045,916.00 (Арван сая дөчин таван мянга есөн зуун арван зургаан) төгрөгийг цалингийн сангаас өөртөө олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**


1. Эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр олгосон 10,045,916 (Арван сая дөчин таван мянга есөн зуун арван зургаан) төгрөгийн төрд учруулсан хохирлыг буруутай албан тушаалтнаар төлүүлэх арга хэмжээ авч, дээрх зөрчлийг таслан зогсоож биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын захирал Ж.Болормаа, ерөнхий нягтлан бодогч С.Бадам нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ
“ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ

Б.СЭРЖМЯДАГ

Н.ЦЭРЭНХАНД



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 210/АД160058
САГ-2021/43/СТА-тмз
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын шилэн дансны цахим сайтад байршуулах нийт 151 мэдээллээс хугацаа хоцроосон 8 мэдээлэл, мөн төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, тушаал шийдвэрийн 79 мэдээллийг цахим хуудсанд байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”; 6 дугаар зүйлийн 6.4.8-д “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын захирал Ж.Болормаа, ерөнхий нягтлан бодогч С.Бадам нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ
“ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Б.СЭРЖМЯДАГ

Н.ЦЭРЭНХАНД



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 209/А0160058
САН-2021/43/СТА-ТМЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагч, эцэг эхчүүдэд хандсан видео шторк бэлтгэх ажлын 15,000,000.00 (Арван таван сая) төгрөгийн үнийн дүн бүхий багц ажлыг 2 байгууллагатай шууд гэрээ байгуулан гүйцэтгэсэн байна.

Энэ нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно", 8.5-д "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тендер шалгаруулалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, алдаа зөрчлийг арилган, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын захирал Ж.Болормаа, ерөнхий нягтлан бодогч С.Бадам нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ
"ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Б.СЭРЖМЯДАГ

Н.ЦЭРЭНХАНД